



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/301

Эрдэнэт

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2/г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, 78.2.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах журам"-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан ажлын шаардлагыг харгалзан аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ашиглагдаж байсан Соната-7 маркийн суудлын автомашиныг Хотын захирагчийн албанд, Хотын захирагчийн албанд ашиглагдаж байсан Хьюнда-Туксон маркийн суудлын автомашиныг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст балансаас балансад шилжүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлэх хөрөнгийг актаар хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газарт, санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэлд зохих журмын дагуу өөрчлөлт оруулахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ